

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

М.БАДАМСҮРЭН

“ХҮН БОЛОХ БАГААСАА” ХҮҮХДИЙН ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨСЛИЙН ТЕЛЕ БОЛОН ЦАХИМ ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий мэдээлэл:

“Хүн болох багаасаа” хүүхдийн гадаад хэлний сургалтын төсөл нь Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/18 дугаар тогтоолоор батлагдсан.

“Хүн болох багаасаа” хүүхдийн гадаад хэлний сургалтын төслийн зорилго нь Дорнод аймгийн хүүхдүүдийн гадаад хэлний мэдлэг чадварыг хөгжүүлэх, багаар ажиллах чадвартай, зөв хүмүүжилтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх.

Хамрах хүрээ, хугацаа: Аймгийн төв болон хөдөөгийн 13 сумын нийт хүүхэд, багачууд, гэр бүлд.

Санхүүжилт:

“Хүн болох багаасаа” хүүхдийн гадаад хэлний сургалтын төслийн зардлаас 15,0 сая төгрөг /орон нутгийн хөгжлийн сан/

Теле болон цахим хичээл сургалт зохион байгуулах ерөнхий шаардлага:

1.	“Хүн болох багаасаа” хүүхдийн гадаад хэлний сургалтын төслийн нэр төрөл: 1. Орос хэлний сургалт 2. Хятад хэлний сургалт 3. Англи хэлний сургалт 4. Япон хэлний сургалт 5. Солонгос хэлний сургалт 6. Хувь хүний хөгжлийн сургалт <i>/Тендэрт оролцогч нь “Хүн болох багаасаа” хүүхдийн гадаад хэлний сургалтын төслийн теле болон цахим хичээл сургалтыг дээрх төрлүүдээр зохион байгуулна/</i>
2.	Теле болон цахим хичээлийг “Хүн болох багаасаа” төслийн гадаад хэлний сургалтын багцыг гүйцэтгэхээр захиалагчтай гэрээ байгуулсан талуудтай хамтран зохион байгуулна.
3.	Теле болон цахим хичээл үзсэн хүүхдүүд, багш, эцэг эхчүүдээс сургалтын явц, үр дүнгийн талаарх санал хүсэлтийг нээлттэй хүлээн авч, эргэх холбоотой хамтран ажиллана.
4.	Теле болон цахим хичээлийг олон нийтэд хэвлэл, мэдээлэл, facebook page болон цахим хуудсаар танилцуулж, түгээн дэлгэрүүлсэн байх.
5.	Теле болон цахим хичээл, контент, мэдээлэлд Дорнод аймгийн лого, төслийн нэр, таних тэмдгийг байршуулсан байх
6.	Зохиогчийн оюуны өмчийн эрх нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу байх
7.	Теле болон цахим хичээл, бусад мэдээллийг DVD болон эх файлаар захиалагч талд хүлээлгэн өгөх

Тендэрт оролцогчдод тавигдах шаардлага:

1.	Тендэрт оролцох албан хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.	Байгууллагын танилцуулга: Үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга
3.	Ажлын туршлага: Теле болон цахим сургалт зохион байгуулж байсан туршлага, амжилтын түүх, хамтран ажилласан байгууллагын мэдээлэл
4.	Хүний нөөцийн мэдээлэл: Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга /сэтгүүлч, зураглаач, техникийн ажилтан зэрэг/
5.	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүчин чадал: Теле болон цахим сургалтыг дамжуулах ТВ суваг, цахим хуудас, facebook page, дүрс, бичлэгийн студи, тоног төхөөрөмж,
6.	Төсвийн дэлгэрэнгүй: Теле болон цахим сургалт зохион байгуулах нийт төсвийн дэлгэрэнгүй задаргаа.

ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБИЛЭГ

Ч.АРИУНАА

